



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/14

Бөхт

Г Гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 109 дүгээр тогтоол, Үнэлгээний хорооны 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 01 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх “Халаалтын шугамын өргөтгөл хийх ажил”-ыг гүйцэтгүүлэхээр “Лорд хаус” ХХК-тай 55,423,158 (тавин таван сая дөрвөн зуун хорин гурван мянга нэг зуун тавин найман) төгрөгөөр гэрээ байгуулсугай.
2. “Халаалтын шугамын өргөтгөл хийх ажил”-ыг зураг төслийн дагуу чанартайгаар гүйцэтгэхийг “Лорд хаус” ХХК-ны захирал (Б.Өнөржаргал)-д үүрэг болгосугай.
3. “Лорд хаус” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д, ажлын явцад гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Мөнхбадрах)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

У.АЛТАНХҮҮ

